



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА**

2022.07.05 № 1339
танай _____-ны № _____-т

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2021 оны 06 дугаар тогтоолыг үндэслэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг төлбөрийн актын хамт Төрийн аудитын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Хавсралт ~~2~~ хуудастай.



Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 6 дугаар сарын 15

№ 184/А0170107

Улаанбаатар хот

АТГ- 2022/16- УТА-ТА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.55 дугаартай Сургуулийн барилга, 480 суудал /Хөвсгөл, Мөрөн сум, 14 дүгээр баг/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх ТӨБЗГ-/2019/XIII.1.1.228 дугаартай 3,999.8 сая төгрөгийн дүнтэй анхны гэрээг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Их эрин констракшн ХХК-тай байгуулжээ. Гэвч 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн ХО2021/50 дугаартай хурлын тэмдэглэлийг үндэслэн 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдөр ТӨБЗГ-/2019/XIII.1.1.288 дугаартай 1,278.9 сая төгрөгийн үнийн дүнтэй нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахдаа төсөвт иж бүрэн тусгаж, өмнөх гэрээний дүнд багтсан гадна дулаан холигчийн узель, дулаан механик, гадна цахилгаан хүчит төхөөрөмж, гадна холбоо, зуухны барилга, дэд өртөөний барилгын ажлын 126,634,738.0 төгрөгийг хасаж тооцоогүй;
2. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.63 дугаартай Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, олон улсын сургалттай “Монгол тэмүүлэл” сургууль/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/202001246 дугаартай 4,977.6 сая төгрөгийн үнийн дүнтэй анхны гэрээг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Батс-Өргөө ХХК-тай байгуулжээ. Гэвч 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр барилга угсралтын ажлын тоо хэмжээний зөрүү, сургуулийн барилгын /920 хүүхэд/ гадна тохижилт, сургуулийн барилгын /640 хүүхэд/ гадна тохижилт, ус дулаан дамжуулах төвийн барилга, гадна дулаан, дулааны узелийн нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгүүлэхээр БСШУСЯ/202001246+2 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 3,500.0 сая төгрөгийн үнийн дүнтэй байгуулсан боловч анхны гэрээний үнэд багтсан 640 хүүхдийн сургуулийн гадна тохижилтын ажлын 88,153,164.0 төгрөгийг тус гэрээний дүнгээс хасаж тооцоогүй;
3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.202 дугаартай Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 50 дугаар цэцэрлэг/ төсөл, арга

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\0615 Auditin 3 Газар-5.Docx

0001090424

хэмжээний барилга угсралтын ажлыг гүйцэтгэх БСШУСЯ/201801165 дугаартай 1,819.7 сая төгрөгийн үнийн дүнтэй анхны гэрээг 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Билэгт багана ХХК-тай байгуулжээ. Гэвч 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 887/2019 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн БСШУСЯ/201801165+1 дугаар нэмэлт санхүүжилтийн гэрээг 272.9 сая төгрөгийн үнийн дүнтэй байгуулж ажлыг хийж гүйцэтгэсэн байхад 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 3,452.0 сая төгрөгийн үнийн дүнтэй БСШУСЯ/201801165+2 дугаар нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулж нэмэлт гэрээгээр гүйцэтгэсэн ажлын 52,347,063.0 төгрөгийг хасаж тооцолгүй, санхүүжилтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;; ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-т “Захиалагчийн чиг үүрэгт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах”, 5.2.7-д “төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт материал, мэдээллүүдийн иж бүрдэл үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5, 4.2.3.6, 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Их эрин констракшн ХХК-д давхардуулан олгосон 126,634,738.0 төгрөг, Билэгт багана ХХК-д давхардуулан олгосон 52,347,063.0 төгрөг, Батс-Өргөө ХХК-д давхардуулан олгосон 88,153,164.0 төгрөг, нийт 267,134,965.0 (хоёр зуун жаран долоон сая, нэг зуун гучин дөрвөн мянга есөн зуун жаран таван) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБЭРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 6 дугаар сарын 15

№ 183/А0170107
АТГ-2022/16-УТА-ТА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.187 дугаартай Цэцэрлэгийн барилга, буулгаж, барих, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 12 дугаар хороо, 20 дугаар цэцэрлэг/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/201902124 дугаартай 1,404.3 сая төгрөгийн үнийн дүнтэй анхны гэрээг 2019 оны 8 дугаар сард Чинбат ХХК-тай байгуулсан бөгөөд төсөвт өртгийг 2019 оны 12 дугаар сард 2,135.6 сая төгрөгөөр баталгаажуулсан 2215/2019 дугаартай МЕД-ийг үндэслэн 2019 оны 12 дугаар сард БСШУСЯ/201902124+1 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 154.2 сая төгрөгөөр, 2021 оны 7 дугаар сард БСШУСЯ/201902124+3 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 577.0 сая төгрөгөөр тус тус байгуулсан боловч тендерийн хэмнэлт болох 154,093,490.0 төгрөгийг хасаж тооцоогүй;
2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад өмнөх онд хэрэгжүүлэхээр баталсан Дотуур байрын барилга, 150 ор /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх ТӨБЗГ-2019/12.1.190 дугаартай 1,467.3 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Онон бридж ХХК-тай байгуулж, 2020 оны 12 сард ашиглалтад хүлээн авчээ. Гэвч 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Боловсролын ерөнхий газрын даргатай 365.5 сая төгрөгийн үнийн дүнтэй нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахдаа тендерийн хэмнэлт 32,488,570.0 төгрөгийг хасаж тооцоогүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д “худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 46 дугаар зүйлийн 46.1.4-д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах”, 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.1-т “Захиалагчийн чиг үүрэгт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\06\15 Auditin 3 Газар-8.Docx

0001090430

байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах”, 5.2.7-д “төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт материал, мэдээллүүдийн иж бүрдэл үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6, 4.2.3.8-д заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Чинбат ХХК-д олгосон 154,093,490.0 төгрөг, Онон Бридж ХХК-д олгосон 32,488,570.0 төгрөг, нийт 186,582,060.0 (Нэг зуун наян зургаан сая, таван зуун наян хоёр мянга, жар) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нар т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

᠒᠐22 оны 6 дугаар сарын 15

№ 182/А0170107

Улаанбаатар хот

АГТ-2022/16 - УГА-ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.136 дугаартай Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Бугат сум/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх ТӨБЗГ/201801121 дугаартай 3,898.7 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр Балкер ХХК-тай байгуулжээ. Гэвч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөв дэх гадна заслын ажлын 120 мм-ийн өнгө өрлөгийг 120 мм-ийн энгийн тоосгон өрлөг, шавардлага болгон өөрчилсөн.
2. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.117 дугаартай Сургуулийн спорт заалны барилга /Ховд, Булган сум, 1 дүгээр сургууль/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/201902109 дугаартай 989.5 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдөр, ХААГ-2016/XII.1.1.163+4 дугаартай нэмэлт санхүүжилтийн 1,500.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр гэрээний үнэд тохируулга хийж Хатан Түнгэл ХХК-тай байгуулсан байна. Гэвч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөвт заасан спорт заалны хэсгийн дүүргэлт, гадна заслын 360 мм-ийн хөнгөн блок, 150 мм-ийн хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн тоосго, шавардлага эмульсийн ажлыг 360 мм-ийн тоосгон өрлөг, 150 мм-ийн хөөсөнцөр дулаалга болгон өөрчилсөн.
3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.88 дугаартай Сургуулийн барилгын өргөтгөл /Хэнтий, Баян-Адарга сум/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/202001288 дугаартай анхны гэрээг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Солармед Монгол ХХК-тай 1,347.6 сая төгрөгийн үнийн дүнтэй, 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр БСШУСЯ/202001036+1 дугаартай нэмэлт санхүүжилтийн гэрээг 152.0 сая төгрөгийн үнийн дүнтэй тус тус байгуулсан байна. Гэвч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөв дэх гадна заслын 360 мм-ийн тоосго, 150 мм-ийн хөөсөнцөр дулаалга, 120 мм-ийн өнгөлгөөний тоосгон өрлөгийн ажлыг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\0615 Auditin 3 Gazar-7.Docx

0001090478

150 мм-ийн хөөсөнцөр дулаалга, шавардлага чулуун гоёл болгон өөрчилсөн байна.

4. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.25 дугаартай Олон улсын стандартын сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх УТХО-2020/53 дугаартай гэрээг 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдөр Хүрэл-Ордон ХХК-тай 5,578.7 сая төгрөгийн үнийн дүнтэй байгуулжээ. Гэвч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөв дэх 3.2 сая төгрөгийн дотор халаалт, цэвэр усны шугамын цутгамал сувгийн тагны ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4-т "Захиалагч барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно", 38 дугаар зүйлийн 38.1.6-д "барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах захиалагчийн санал барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт тавих чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрч, баталгаажуулах", 40 дүгээр зүйлийн 40.1.1-д "барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих", 40.1.17-д "барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах", ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.1-т "Захиалагчийн чиг үүрэгт ТАХ-ний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баккер ХХК-ийн барилгын гадна заслын ажлын өнгө өрлөгийг энгийн тоосгон өрлөг, шавардлага болгон өөрчилж хийсэн ажлын өртгийн зөрүү 545,905.0 төгрөг, Хатан Түнгэл ХХК-ийн барилгын спорт заалны хэсгийн дүүргэлт, гадна заслын ажлын хөнгөн блок, хөөсөнцөр дулаалга, тоосго, шавардлага эмульсийг тоосгон өрлөг, хөөсөнцөр дулаалга болгон өөрчилж хийсэн ажлын өртгийн зөрүү 3,490,110.0 төгрөг, Солармед Монгол ХХК-ийн барилгын гадна заслын ажлын тоосго, хөөсөнцөр дулаалга, өнгөлгөөний тоосгон өрлөгийг хөөсөнцөр дулаалга, шавардлага чулуун гоёл болгон өөрчилж хийсэн зөрүү

361,286.0 төгрөг, Хүрэл-Ордон ХХК-ийн батлагдсан зураг төсөл, төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй ажлын 3,200,000.0 төгрөг нийт 7,597,301.0 (Долоон сая, таван зуун ерэн долоон мянга, гурван зуун нэг) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Д.ЭНХБОЛД

АУДИТОР



С.ОДОНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 6 дугаар сарын 15

№ 181 / А 0170107

Улаанбаатар хот

АТ - 2022/16 - УТА - ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.4.1.1.4 дугаартай Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Морин хуур" хөгжим худалдан авах төсөл, арга хэмжээний хүрээнд морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-04 дугаартай 521.1 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай, XIII.4.1.1.9 дугаартай Ерөнхий боловсролын сургуульд "Морин хуур" хөгжим худалдан авах төсөл, арга хэмжээний хүрээнд морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-09 дугаартай 631.4 сая төгрөгийн гэрээг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаартай комиссын актаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 521.1 сая төгрөгийн үнэ бүхий 2348 ширхэг, Ерөнхий боловсролын сургуульд 631.4 сая төгрөгийн үнэ бүхий 2388 ширхэг, нийт 1,152.5 сая төгрөгийн үнэ бүхий 4736 ширхэг морин хуур хөгжим хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэвч аудитаар 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Эгшиглэн Магнай ХХК-ийн агуулахад хийсэн тооллогоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлэх 400 ширхэг морин хуурыг үйлдвэрлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "Захиалагчийн эрх, үүрэгт худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 46.1.6-д "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах" Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана", 3.4-т "ТЕЗ нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллана", гэрээний 4 дүгээр зүйлд "нийлүүлэгч нь хавсралтад дурдсан барааг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө", гэрээний тусгай нөхцөлийн 8 дугаар зүйлд "барааг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 100 хувьтай тэнцэх төлбөрийг төлнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akr\2022\0615 Auditin 3 Газар-10.Docx

0001090434

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7, 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эгшиглэн Магнай ХХК-д сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлэх үйлдвэрлээгүй 400 ширхэг морин хуурын 88,774,400.0 (Наян найман сая, долоон зуун далан дөрвөн мянга, дөрвөн зуун) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 6 дугаар сарын 15

№ 180/АД 170107

Улаанбаатар хот

АТГ- 2022/16 - 107А-1А

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.109 дугаартай Сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 118 дугаар сургууль/ төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах 29,100,000.0 төгрөгийн үнийн дүнтэй гэрээг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар 2013 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Балданс ХХК-тай байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байхад батлагдсан зураг төсөл, төсвийн үнэ 29,100,000.0 төгрөгийг Чулуутын багш ХХК-д гүйцэтгэлээр давхардуулан олгосон;
2. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.3.1.2.2 дугаартай Багшийн хөгжлийн ордны дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх 15 дугаартай 57,537.3 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Гом Илч ХХК-тай байгуулж, 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 01 дугаартай комиссын актаар хүлээн авсан байна. Ажил гүйцэтгэх явцад зураг төсөл зохиогч, болон захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй боловч зохиогч, захиалагчийн хяналтын зардлын 699,361.8 төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны яамны дансанд шилжүүлсэн.
3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.3.1.2.3 дугаартай Багшийн хөгжлийн ордны дулаан лифт засвар төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх БШУЯ/202102137/23 дугаартай 78,801.3 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Цамхаг констракшн ХХК-тай байгуулж, 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 02-07-025/369 дугаартай комиссын актаар хүлээн авсан байна. Ажил гүйцэтгэх явцад зураг төсөл зохиогч, болон захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй боловч зохиогч, захиалагчийн хяналтын зардлын 684,158.0 төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны яамны дансанд шилжүүлсэн.
4. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.3.1.2.4 дугаартай Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн их

засвар төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх БШУЯ/202102138/02 дугаартай 34,993.8 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Хунт-Улз ХХК-тай байгуулж, 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр комиссын актаар хүлээн авсан байна. Гэвч ажлын явцад захиалагчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй боловч захиалагчийн хяналтын 996,457.0 төгрөгийн зардлын Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-д *санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах; дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.1-т "*Захиалагчийн чиг үүрэгт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах*", 5.2.7-д "*төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт материал, мэдээллүүдийн иж бүрдэл үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ*" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.6, 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Чулуутын багш ХХК-д гүйцэтгэлээр олгосон 29,100,000.0 төгрөг, Багшийн хөгжлийн ордны дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлын 699,361.8 төгрөг, Багшийн хөгжлийн ордны дулаан лифт засвар төсөл, арга хэмжээний зураг төсөл зохиогчийн хяналтын зардлын 684,158.0 төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн их засвар төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлын 996,457.0 төгрөг, нийт 31,479,976.8 (гучин нэгэн сая, дөрвөн зуун далан есөн мянга, есөн зуун далан зургаан төгрөг наян мөнгө) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.ЭНХБОЛД
АУДИТОР  С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 6 дугаар сарын 15

№ 179/А0170107

Улаанбаатар хот

АТГ- 2022/16-УТА-1А

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.272 дугаартай Архангай аймгийн оюутны дотуур байрын спорт заалны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр газрын асуудал шийдвэрлээгүй, хэрэгжих нөхцөл бүрдээгүй байхад тус барилгын 748,298,717.0 төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ, 29 дүгээр зүйлийн 29.4-т "хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана". Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-т "газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх", 35.1.6-д "газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 7.2-т "төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ТАХ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй, үүнд эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдах этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\06\15 Auditin 3 Gazar-9.Docx

0001090432

1. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Архангай аймгийн оюутны дотуур байрын спорт заалны барилгын 748,298,717.0 (Долоон зуун дөчин найман сая хоёр зуун ерэн найман мянга долоон зуун арван долоон) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.САРУУЛ

АХЛАХ АУДИТОР



Б.БАТДЭЛГЭР

АУДИТОР



С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 6 дугаар сарын 16

№ 178/А 0170107

Улаанбаатар хот

АТГ- 2022/16 - 117А - ТА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн дотуур байранд тавилга нийлүүлэх БСШУСЯ/202002507 дугаартай 1,187.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Евро-Электроникс ХХК-тай байгуулсан боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Бараа материалын тайланд 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 2 нэр төрлийн 16,907.3 мянган төгрөгийн үнэ бүхий 84 ширхэг барааны үлдэгдэлтэй байна. Аудитаар Евро-Электроникс ХХК-ийн агуулахад тооллого хийхэд 132.5 сая төгрөгийн үнэ бүхий 385 ширхэг бичиг хэргийн шүүгээг үйлдвэрлээгүй байна.
2. Ерөнхий боловсролын сургуулиудад сурагч ширээ, сандал нийлүүлэх БСШУСЯ/202002507 дугаартай 1,915.2 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Долоон Болдог ХХК-тай байгуулсан боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Бараа материалын тайланд 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 28 нэр төрлийн 220.9 сая төгрөгийн үнэ бүхий 5534 ширхэг барааны үлдэгдэлтэй байна. Аудитаар Долоон Болдог ХХК-ийн агуулахад тооллого хийхэд 13 нэр төрлийн 232.5 сая төгрөгийн үнэ бүхий 3518 ширхэг барааг үйлдвэрлээгүй байна.
3. Дээрх гэрээнүүдэд "...хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.3 хувь, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна" гэж заасан боловч нийлүүлэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хариуцлага тооцоогүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "Захиалагчийн эрх, үүрэгт худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 46 дугаар зүйлийн 46.1.6-д гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана", 3.4-д "ТЭЗ нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2022\0615 Auditin 3 Газар-11.Docx

0001090436

баталж, хэрэгжилтийг ханган ажиллана", гэрээний 4 дүгээр зүйлд "нийлүүлэгч нь хавсралтад дурдсан барааг 2020 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7, 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Евро-Электроникс ХХК-тай байгуулсан гэрээний тусгай нөхцөлийн 17.1-д "...хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.3 хувь, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна" гэж заасны дагуу үйлдвэрлээгүй 385 ширхэг барааны 132,505,184.3 төгрөгийн үнийн дүнгээс тооцсон алданги 6,625,259.2 төгрөг, Долоон Болдог ХХК-тай байгуулсан гэрээний тусгай нөхцөлийн 17.1-д "...хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.3 хувь, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна" гэж заасны дагуу үйлдвэрлээгүй 13 нэр төрлийн 3518 ширхэг барааны 232,464,597.1 төгрөгийн үнийн дүнгээс тооцсон алданги 11,623,229.9 төгрөг, нийт 18,248,489.1 (арван найман сая, хоёр зуун дөчин найман мянга, дөрвөн зуун дөчин есөн төгрөг арван мөнгө) төгрөгийг Төв төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 962 / А0170107

Улаанбаатар хот

АГТ- 2022/16 - УМТА - АА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.63 дугаартай Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, олон улсын сургалттай “Монгол тэмүүлэл” сургууль/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Батс-Өргөө ХХК-тай, XIII.1.1.165 дугаартай Цэцэрлэгийн барилга, 320 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр ГЦЦЭ ХХК-тай, Сургуулийн барилга, 920 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Неман Констракшн ХХК-тай тус тус байгуулан ажил гүйцэтгүүлсэн байна.

Дээрх сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгуудын дулааны холболтыг хамгийн ойр байрлах Шинэ зуун айл ХХК шугамнаас холбох талаар Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраас тус компанитай зөвшилцөж, харилцан тохиролцсоны үндсэн дээр олгосон Эрчим төсөл ХХК-ийн ЭТ-49/2018 дугаартай гадна дулаан, дулаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу хийхээр шийдсэн байна. Уг нөхцөлийн дагуу 2020 онд Эрчим төсөл ХХК-ийн ЭТ-24/2020 дугаартай гадна дулаан, дулаан механизмын зураг төслийг баталж, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох 044/2020 дугаартай техникийн нөхцөлийг БСШУСЯ-д олгож, техникийн нөхцөлийн дагуу гадна дулааны шугамын ажлыг хийж гүйцэтгэхэд нийт 534,842,422.0 төгрөгийг зарцуулсан байна.

Гэвч өнөөдрийн байдлаар шугам эзэмшигч Шинэ зуун айл ХХК тус сургууль, цэцэрлэгийн барилгуудыг холбуулахгүй гэсэн шалтгаанаар дулааны шугам угсралт, холболтын ажил зогссон байна. Улмаар Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгээс 021/2022 дугаартай холболтын цэгийг өөрчлөх техникийн нөхцөлийг 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр БШУЯ-нд олгож, 2022 оны Нийслэлийн Хөрөнгө оруулалтын төсвийн саналд 5,000,000,000.0 төгрөг тусгахаар ажиллаж байгаа нь урьдчилсан тооцоогоор 4,209,580,316.0 төгрөгийн үр ашиггүй зардал гарахаар байна.

0001082427

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9-д хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй, 30 дугаар зүйлийн 30.1.10-т түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах; ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах, Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 2.5-д Ажлын хэсэг техникийн нөхцөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ дараах саналыг үндэслэнэ. Үүнд: 2.5.1-д тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний техникийн боломж; 2.10-д Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-т заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ. 2.12-д Захиалагч иргэн, хуулийн этгээд нь зураг төслийн байгууллагатай хамтран барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө холбогдох байгууллагуудаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж, баталгаажуулсан байна гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх албан шаардлага өгөх нийтлэг үндэслэлийн 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, олон улсын сургалттай "Монгол тэмүүлэл" сургууль/, Цэцэрлэгийн барилга, 320 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ Сургуулийн барилга, 920 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ барилгуудын дулааны холболтыг хамгийн ойр байрлах дулааны шугамаас холбох, үргүй зардал гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 963/А0140086

Улаанбаатар хот

АГГ- 2022/16- ИТА-1А

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан 9 /Хүснэгт 1/ төсөл, арга хэмжээ, он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй XIII.1.1.150 дугаартай Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо/, нийт 23,668.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг хувааж тендер зарласан байна. Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан төсөвт өртгийн зөрүүг тооцоход 9,660,780,000.0 төгрөг болж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", ТБОНӨХБАУХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тээш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "тендер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", ТБОНӨХБАУХАТХуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар "Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг зөрчсөн төрийн албан хаагчдад уг хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцох" зөвлөмжийг хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан ажлын тоо хэмжээг хувааж
төндөр зарласан төсөл, арга хэмжээний жагсаалт, сая төгрөг

д.д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	МЕД-ийн дугаар	Магадлалаар баталгаажсан төсөвт өртөг	Шаардлагатай төсөвт өртгийн зөрүү
1	XIII.1.1.150	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо/	2020	2021	1,500.0	1,450.0	1622/2021	2,900.0	1,400.0
2	XIII.1.1.216	Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Тонхил сум/	2021	2022	2,800.0	320.0	545/2021	5,295.4	2,495.4
3	XIII.1.1.222	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Бор-Өндөр сум/	2021	2022	2,200.0	1,000.0	352/2021	2,539.1	339.1
4	XIII.1.1.223	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Хэнтий, Дархан сум/	2021	2021	630.0	630.0	624/2021	951.7	321.7
5	XIII.1.1.225	Дотуур байрын барилга, 100 ор /Хэнтий, Дэлгэрхаан сум/	2021	2022	1,400.0	700.0	339/2021	2,099.8	699.8
6	XIII.1.1.228	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Цэнхэр сум/	2021	2022	1,500.0	500.0	768/2021	2,393.3	893.3
7	XIII.1.1.252	Бага сургууль, цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 6 дугаар хороо/	2021	2022	3,300.0	1,000.0	1077/2021	3,993.2	693.2
8	XIII.1.1.257	Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Цээл сум/	2021	2022	3,938.5	400.0	431/2021	4,877.8	939.3
9	XIII.1.1.275	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 34 дүгээр сургууль/	2021	2022	4,700.0	2,000.0	675/2021	5,006.5	306.5
10	XIII.1.1.255	Дотуур байрын барилга, 100 ор /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2021	2022	1,700.0	420.0	1549/20221	3,272.5	1,572.5
ДҮН					23,668.5			33,329.3	(9,660.8)



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 961 /А0170107

Улаанбаатар хот

АТГ-2022/16-ШТА-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.2.22 дугаартай Цэцэрлэгийн барилга их засварын /Ховд, Булган/ төсөл, арга хэмжээний БШУЯ/202001153 дугаартай Харганы Ус ХХК-тай 447.8 сая төгрөгийн дүнтэй ажил гүйцэтгэх гэрээг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан боловч ажлын зураг төсөл, төсөв магадлалаар баталгаажуагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.10-т "барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах", Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.2.1-т "Захиалагчийн чиг үүрэгт ТАХ-ний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх албан шаардлага өгөх нийтлэг үндэслэлийн 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харганы Ус ХХК-ийн гүйцэтгэсэн цэцэрлэгийн барилгын их засварын /Ховд, Булган/ ажлын 447,827,694.00 төгрөгийн ажлын зураг төсөл, төсвийг магадлалаар баталгаажуулах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

Z:\Alban Shaardlaga\2022\0615 Auditin 3 Газар-12.Docx

00010824!9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 960/А0170107

Улаанбаатар хот

АТТ- 2022/16 - УИТА - ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Боловсролын салбарын 2021 оны Бараа материалын тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2020, 2021 онд гэрээ байгуулсан 29 компанийн 42757 ширхэг 6,641.5 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэлтэй байна.
2. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.4.1.1 дугаартай Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ын тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмж нийлүүлэх 875.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Ай Тй Зон ХХК-тай байгуулж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1 дугаартай комиссын актаар 18 нэр төрлийн 568 ширхэг тоног төхөөрөмж хүлээн авсан боловч ашиглалтгүй байна.
3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.4.1.1.4 дугаартай Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Морин хуур" хөгжим худалдан авах төсөл, арга хэмжээний морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-04 дугаартай 521.1 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай, XIII.4.1.1.9 дугаартай Ерөнхий боловсролын сургуульд "Морин хуур" хөгжим худалдан авах төсөл, арга хэмжээний морин хуур хөгжим нийлүүлэх БШУЯ/202102132-09 дугаартай 631.4 сая төгрөгийн дүнтэй гэрээг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Эгшиглэн Магнай ХХК-тай тус тус байгуулж, 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн комиссын актаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 521.1 сая төгрөгийн үнэ бүхий 2348 ширхэг, Ерөнхий боловсролын сургуульд 631.4 сая төгрөгийн үнэ бүхий 2388 ширхэг, нийт 1,152.5 сая төгрөгийн үнэ бүхий 4736 ширхэг морин хуур хөгжим хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэвч ашиглагч байгууллагад нийлүүлээгүй 1,031.3 сая төгрөгийн үнэ бүхий 4212 ширхэг морин хуурын үлдэгдэлтэй байна.
4. XIII.4.1.1.7 дугаартай Ерөнхий боловсролын сургуулийн цайны газар, сургуулийн дотуур байранд гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах 1,285.8 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Голден дрийм ХХК-тай байгуулж, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/102 дугаартай бараа хүлээн авах комиссын актаар 12 нэр төрлийн 1,285.8 сая төгрөгийн үнэ бүхий 2476 ширхэг гал тогооны тоног төхөөрөмж хүлээн авч,

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0615 Auditin 3 Газар-13.Docx

0001082421

- санхүүжилтийг бүрэн олгосон боловч ашиглагч байгууллагад нийлүүлээгүй 12 нэр төрлийн 1715 ширхэг 1,065.7 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй байна.
5. Сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, ширээ сандал, тавилга хэрэгсэл худалдан авах 631.4 сая төгрөгийн үнийн дүнтэй ерөнхий гэрээг Төрийн худалдан авах ажиллагааны газар 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдөр Анун ХХК-тай хийснийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны яам 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Анун ХХК-тай худалдан авах гэрээг байгуулж, 2021 оны 12 дугаар сард бараа хүлээн авах комиссын актаар 275 ширхэг 137.5 сая төгрөгийн үнэ бүхий багшийн бичгийн шүүгээг хүлээн авч санхүүжилтийг олгосон байна. Гэвч аудитаар 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 275 ширхэг 137.5 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй, ашиглагч байгууллагад нийлүүлээгүй байна.
 6. Ерөнхий боловсролын сургуулиудад сурагч ширээ, сандал нийлүүлэх гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Долоон Болдог ХХК-тай байгуулсан боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Аудитаар 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 28 нэр төрлийн 5534 ширхэг 220.9 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй, 13 нэр төрлийн 3518 ширхэг 232.5 сая төгрөгийн үнэ бүхий барааг үйлдвэрлээгүй байна.
 7. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн дотуур байранд тавилга нийлүүлэх гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Евроэлектроникс ХХК-тай байгуулсан боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Аудитаар 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 2 нэр төрлийн 84 ширхэг 16.9 сая төгрөгийн үнэ бүхий барааны үлдэгдэлтэй, 385 ширхэг 132.5 сая төгрөгийн үнэ бүхий барааг үйлдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана", 3.4-д "ТЭЗ нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллана", 7.3.3-т "холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх албан шаардлага өгөх нийтлэг үндэслэлийн 4.2.1.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүлээн авсан боловч ашиглагч байгууллагад нийлүүлээгүй 55145 ширхэг 9,988,829,238.90 төгрөгийн, санхүүжилтийг бүрэн олгосон боловч гүйцэтгэгч байгууллага үйлдвэрлээгүй 3903 ширхэг 364,969,781.40 төгрөгийн, нийт 10,353,809,020.30 (арван тэрбум, гурван зуун тавин гурван сая, найман зуун есөн мянга, хорин төгрөг гучин мянга) төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор ашиглагч байгууллагад нийлүүлэх,
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 959/А-0170107

Улаанбаатар хот

АТГ- 2022/16 - ШТА-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.81 дугаартай Сургуулийн барилга, урлаг заал, 320 суудал /Хэнтий, Батноров сум/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/202001317 дугаартай 3,845.4 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр СИ ЭЙЧ БИ ЖИ КОНСТРАКШН ХХК-тай байгуулсан боловч барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл 25-30 хувьтай байхад 53.9 хувийн гүйцэтгэл гаргаж, 2,073.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т "барилгын үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан зохицуулж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх"; ТБОНӨХБАУХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана", 5.2.1-т "Захиалагчийн чиг үүрэгт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах", 5.2.7-д "төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт, материал, мэдээллүүдийн иж бүрэн, үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ", 9.4-д "Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төсөл, арга хэмжээний зураг, төсөл болон төсвийн дагуу барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0615 Auditin 3 Gazar-10.Docx

0001082415

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Барилгын ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулах, зохиогч болон захиалагчийн хяналтыг бүрэн хангуулах, Б блокийн цутгамал төмөр бетон хийцийг батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгүүлэх, харуул хамгаалалт, талбайн зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авах;
2. Албан шаардлагын биелэлтийг биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР


Б.САРУУЛ

АХЛАХ АУДИТОР

Б.БАТДЭЛГЭР

АУДИТОР

С.ОДОНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 958 / 10170107

Улаанбаатар хот

АТГ - 2022/16-ШТА-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.65 дугаартай Цэцэрлэгийн барилга, 320 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх БСШУСЯ/202001313 дугаартай 2,600.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр ГЦЦЭ ХХК-тай байгуулсан боловч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсөвт тусгасан дээврийн ажлыг мембранаар хийх байсныг хар цаас болгон өөрчилсөн;
2. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан XIII.1.1.118 дугаартай Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр сургууль/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх 968.9 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2020 оны 7 дугаар сард Офис констракшн ХХК-тай байгуулсан боловч гүйцэтгэгч компани батлагдсан зураг төсөл, төсвийн дагуу хүзүүвчний ажлыг хийж гүйцэтгээгүй;
3. Өмнөх онд хэрэгжсэн Дотуур байрны барилга 150 ор /Дадал сум/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх 1,439.4 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2019 оны 7 дугаар сард Ганбүрд ХХК-тай байгуулж, 2020 онд байнгын ашиглалтад хүлээн авсан боловч барилгын дээврээс ус алдаж, дотор хана мөөгөнцөртсөн, розетка, гадна дотор камер ажиллахгүй, бохирын шугам хөлдсөн, дотор дүүжин таазыг галд тэсвэргүй материалаар хийсэн, барилгын хаяавч суулт өгч, ан цав үүссэн;
4. Өмнөх онд хэрэгжсэн Дотуур байрын барилга, 150 ор /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх 1,467.3 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг 2019 онд Онон бридж ХХК-тай байгуулж, 2020 оны 12 дугаар сард байнгын ашиглалтад хүлээн авсан боловч барилгын хаяавч бетон суусан, ханын хагарал үүссэн, бохирын худаг хальсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна., 14.7-д Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0615 Auditin 3 Газар-9.Docx

0001082413

төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна. 40 дүгээр зүйлийн 40.1 дэх Барилгын ажил гүйцэтгэгч чиг үүргийн 40.1.1-д "барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих"; Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцан ажиллана", 5.2.1-д "Захиалагчийн чиг үүрэгт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгагдсан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх албан шаардлага өгөх нийтлэг үндэслэлийн 4.2.1.8-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ГЦЦЭ ХХК-ийн гүйцэтгэсэн Цэцэрлэгийн 320 ортой барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/-ын дээврийн ажил, Офис констракшн ХХК-ийн гүйцэтгэсэн Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр сургууль/-ын хүзүүвчний ажлыг тус тус батлагдсан зураг төслийн дагуу 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн дотор хийж гүйцэтгүүлэх;
2. Ганбүрд ХХК-ийн гүйцэтгэсэн Дотуур байрны 150 ортой барилга /Дадал сум/ -ын засвар, Онон бридж ХХК-ийн гүйцэтгэсэн Дотуур байрны 150 ортой барилга /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ын засварын ажлыг 2022 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн дотор хийж гүйцэтгүүлэх;
3. Албан шаардлагын биелэлтийг биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 6 дугаар сарын 15

№ 957/А0170107

Улаанбаатар хот

АТГ-2022/16-ШТА-ГА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр баталсан газрын асуудал шийдвэргүй шинээр хэрэгжих 7 /хавсралт 1/, өмнөх оны зураг төсөвгүй 14 /хавсралт 2/ нийт 21 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, гэрээ байгуулсан байна. Зураг төсөвгүй тендер зарлаж, гэрээ байгуулснаас төсөвт өртөг 12,499.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2-т “төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ТАХ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй, үүнд эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-т “газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх”, 35.1.6-д “газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгөөр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх албан шаардлага өгөх нийтлэг үндэслэлийн 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлуулан

- хэрэгжүүлж байх, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээнд тендер зарлаж байх, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Д.ЭНХБОЛД

С.ОДОНЦЭЦЭГ